ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023-2024 ОНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр — Баян-Өндөр сум

| № | Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратегийн зорилт арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллах | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг нас, насны ангиллаар авч, сорилын программд шивэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх | 2021-2024 | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлж хувиар тооцно. | Улсын төсөв | - | 2019 онд 46.8 хувь | 2024 онд 51.6 хувьд хүргэх | - | - | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 2023 онд сорилд хүн амын 9 хувь буюу 9631 иргэн, 2024 онд 2 удаа зохион байгуулж, хүн амын 14.8 хувь буюу 15642 иргэдийг хамруулснаас 54.1% нь А, В, С үнэлгээтэй байна. Өмнөх оноос бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин хэвийн үзүүлэлттэй иргэдийн тоог 285-аар нэмэгдүүлсэн. | 100% |
| 2 | | Баян-Өндөр, Жаргалант суманд орон | 2021-2024 | Баян-Өндөр, Жаргалант суманд нийт 2 | Улсын төсөв | - | - | 2022 онд 2 арга зүйчээр нэмэгдүүлнэ | | | Тус аймаг нь Баян-Өндөр, Жаргалант 2 сумтай бөгөөд 2020-2021 онд Баян-Өндөр, Жаргалант суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажилласан. Жаргалант суманд биеийн тамирын арга зүйч | 50% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх | | арга зүйчтэй болсон байна. | | | | | | | ажиллаж байсан боловч хүүхэд харах чөлөө авч, 2023-2024 онд орон тоо нөхөгдөөгүй. | |
| 3 | | Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах | 2021-2024 | Аймгийн хэмжээнд нийт 10 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана. | Улсын төсөв | - | 2020 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг спорт холбоо клубүүдийн нэгдсэн судалгаа авах | 2024 онд 14 спорт холбоо | Улсын төсөв 69.1, Орон нутгийн төсөв 360.4 сая төгрөг | Улсын төсөв 69.1, Орон нутгийн төсөв 360.4 сая төгрөг | Биеийн тамир, спортын газар нь биеийн тамир, спортын 28 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж 2023 онд улсын төсвөөс 346.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 390.0 сая төгрөг, 2024 онд улсын төсвөөс 69.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 360.4 сая төгрөгийн санхүүжилтийг спорт холбоодод тус тус олгож, тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулсан. | 100% |
| 4 | | Орхон аймгийн хэмжээнд спортын талбай, гэр хорооллын дундах тоглоомын талбайд | 2021-2024 | 8 талбайд тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөний хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Орон нутгийн төсөв | - | 2020 онд нийт 23 талбай байгаагаас 2 талбайд иргэд тогтмол дасгал хөдөлгөөни | 2024 онд 8 талбайд дасгал хөдөлгөөн хийх | - | - | Амралт, чөлөөт цагийн талбайд 2021-2023 онд 27 удаа дасгал хөдөлгөөн, тэмцээн уралдаанд 3480 иргэдийг хамруулсан.<br><br>Тайлант онд 122 амралт, чөлөөт цагийн талбай ашиглагдаж, 10 удаа гадаа талбайд уралдаан тэмцээн, дасгал хөдөлгөөний арга хэмжээ зохион байгуулж, 4760 иргэнийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөний хийх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | йг хийж байна | | | | | |
| 5 | | Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх | 2021-2024 | Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд 28 спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршсан байна. | Улсын төсөв | - | 2020 онд техник эдийн засгийн үзүүлэлт хийгдсэн байна. | 2024 онд 6 спорт холбоо | - | - | Биеийн тамир, спортын газар нь Орхон аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын 26 төрийн бус байгууллагаас 11 спорт холбоодын мэдээллийг www.orkhon.sport.gov.mn сайтад нээлттэй байршуулж, цахим сан үүсгэн ажилласан. | 100% |
| 6 | | Биеийн тамирын арга зүйчдийг мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулна. | 2021-2024 | Биеийн тамирын 6 арга зүйчийг мэргэшүүлэх давтан сургалтад хамруулсан байна. | Улсын төсөв | - | - | 2024 онд 2 арга зүйчийг мэргэшүүлсэн байна. | - | - | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад 2023-2024 онд биеийн тамирын 1 арга зүйч, 4 мэргэжилтнийг дотоодод, 1 мэргэжилтнийг гадаад улсад тус тус хамруулсан. | 100% |
| 7 | Зорилт-2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй | Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубийн тоог нэмэгдүүлэх | 2021-2024 | Спортын магадлан итгэмжлэлд 5 фитнес клубийг хамруулсан байна. | Улсын төсөв | - | Аймгийн хэмжээнд 11 фитнес клуб ажиллаж байна. 2020 оны байдлаар 3 фитнес клуб спортын магадлан | 2024 онд – 1 фитнес клуб шинээр спортын магадлан итгэмжлэлд хамрагдсан байна | - | - | Аймгийн хэмжээнд 2021-2023 онд фитнес клуб 1-ээр, хичээллэгчдийн тоог 200-аар нэмэгдүүлж, 14 фитнес клубт 1900 иргэн тогтмол хичээллэсэн. Тайлант онд фитнес клуб 1-ээр, хичээллэгчдийн тоог 100-аар тус тус нэмэгдүүлж, 15 фитнес клубт 2000 иргэн хичээллэж байна.<br>Фитнес клубүүдээс 3 нь 2021 онд 1-2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн болович 2023 оноос | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт, баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ | | | | | | итгэмжлэл авсан. | | | | магадлан итгэмжлэх үйл ажиллагаа улсын хэмжээнд зогссон. | |
| 8 | | Улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах | 2021-2024 | Улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа 5 удаа зохион байгуулсан байна. | Орон нутгийн төсөв | - | 2020 онд улс, бүсийн чанартай 2 тэмцээн зохион байгуулсан | 2024 онд 5 удаа улс, бүсийн чанартай тэмцээнийг зохион байгуулсан байна. | Орон нутгийн төсөв - 142.7 сая төгрөг | Орон нутгийн төсөв - 142.7 сая төгрөг | Орон нутагтаа 2021-2023 онд улс аварга шалгаруулах тэмцээн 14 удаа, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 6 удаа тус тус зохион байгуулж 6782 тамирчин хамруулж, улсын төсвөөс 275.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 312.4 сая төгрөг зарцуулсан. Орхон аймагт 1.236.526.200 төгрөг хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажилласан.<br><br>Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 9, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 тус тус зохион байгуулж, нийт 4162 тамирчин оролцсон. Тэмцээн уралдаан зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 124.7 сая төгрөг зарцуулж, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн. | 100% |
| 9 | | Спортын хэрэгслийн /дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр, чарга/ түрээсийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, иргэний санал санаачилгыг дэмжиж зам талбай, орчин | 2021-2024 | Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдэж, зам талбай, орчин нөхцөлөөр дэмжиж ажилласан байна. | Орон нутгийн төсөв | - | - | Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдэж, тэднийг үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлөөр дэмжиж ажиллана. | - | - | Аймгийн хэмжээнд 2021-2023 онд 6 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжээс уулын цана, чарга, тэшүүр, цахилгаан дугуй /скүүтер/, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 7200 гаруй хүүхэд залууст хүргэж ажилласан.<br>Тайлант онд 5 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжээс уулын цана, чарга, тэшүүр, гэр бүлийн дугуй, дугуйн түрээсийн үйлчилгээг 7400 гаруй хүүхэд, залууст үзүүлсэн. Үүнд:<br>-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 2200 иргэн;<br>- 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 иргэн; | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | | нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | | -"Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 650 иргэн, гэр бүлийн дугуйн түрээсийн үйлчилгээнд 1250 иргэн;<br>“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд” дугуйн түрээсийн үйлчилгээнд 1500 иргэн;<br>-15-р сургуулийн мөсөн талбайн тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 600 хүүхэд залуус тус тус хамрагдсан. | |
| 10 | | Хүн амын зорилтот бүлгүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулж, хамтарч ажиллах | 2021-2024 | Нийт ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, зохион байгуулах арга хэмжээний тоо | Улсын төсөв | - | 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд ахмад настан 12259 хүн, хөгжлийн бэрхшээлтэй 4226 иргэн амьдарч байна. Спортоор хичээллэгч ахмад настан 750, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 250 байна. Биеийн тамир, спортын арга хэмжээг 10 удаа зохион байгуулж байна. | 2024 онд ахмад настан 1000, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 400, арга хэмжээ 13 удаа зохион явуулна. | Улсын төсөв -9.5 сая төгрөг | Улсын төсөв -9.5 сая төгрөг | Аймгийн хэмжээнд 2021-2023 онд ахмад настнуудын дунд спортын 10 төрлөөр 28 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 2100 ахмад настнуудыг хамруулсан.<br>Тайлант онд ахмадуудын дунд спортын 9 төрлөөр 12 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж, 1132 ахмад тамирчдыг хамруулсан.Тэмцээн уралдаан зохион байгуулахад улсын төсвийн 4,5 сая төгрөг зарцуулсан.<br><br>Аймгийн хэмжээнд 2021-2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэд спортын 9 төрлөөр тогтмол хичээллэж, 26 удаагийн тэмцээн уралдаанд давхардсан тоогоор 981 иргэдийг оролцуулсан.<br>Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 9 төрлөөр 10 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж, 435 тамирчдыг хамруулсан.Тэмцээн уралдааны зохион байгуулалтад улсын төсвийн 5,0 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 11 | | Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг | 2021-2024 | Аянд хамрагдсан байгууллагын тоо, хамрагдса | Орон нутгийн төсөв | - | - | 2024 онд 35, байгууллага 9000 хүн | Орон нутгийн төсөв -15.0 сая | Орон нутгийн төсөв -15.0 сая | Аймгийн хэмжээнд хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аянд 2021-2023 онд 76093 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчилж “ Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх | | н хүний тоо | | | | | төгрөг | төгрөг | Тайлант онд "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд 8 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 47 байгууллагын давхардсан тоогоор 38.000 мянган иргэнийг хамруулсан. Тус арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөг зарцуулсан. | |
| 12 | Зорилт-3. Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах | Аймгийн хэмжээнд Иргэдийн спортын наадмыг жил бүр зохион байгуулах | 2021-2024 | Иргэдийн наадам Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд спортын 8 төрлөөр зохион байгуулж 2400 иргэн хамрагдсан байна. | Орон нутгийн төсөв | - | Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд спортын 5 төрлөөр зохион байгуулж 1606 иргэн хамрагдсан. | 2024 онд спортын 8 төрлөөр зохион байгуулж 2400 иргэн хамрагдсан байна. | Орон нутгийн төсөв -23.0 сая төгрөг | Орон нутгийн төсөв -23.0 сая төгрөг | Иргэдийн спортын наадмыг үндэсний болон багийн спортын 6 төрлөөр 2021-2022 онд зохион байгуулж, 1797 иргэнийг хамруулж, 12.8 сая төгрөг зарцуулсан.<br>2023 онд Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион байгуулж сагсан бөмбөгийн төрөлд 308, волейболын төрөлд 384, олс таталтын төрөлд 184, ширээний теннисний төрөлд 46, үндэсний бөхийн төрөлд 69, буудлагын төрөлд 92, дартсын төрөлд 46, Мас-рестлинг /Модон барилдаан/-ны төрөлд 32 иргэн тус тус оролцож нийт 1143 иргэн хамрагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан.<br><br>Тайланд онд “Иргэдийн спортын наадам”-ыг багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж, 1221 иргэн оролцсон. Тэмцээн зохион байгуулахад орон нутгийн төсвийн 23.0 сая төгрөгийг зарцуулсан. | 100% |
| 13 | | Үндэсний уламжлалт спортын төрлүүдээр аймгийн хэмжээнд аймгийн | 2021-2024 | Үндэсний спортын 7 төрлөөр аймгийн хэмжээнд тэмцээний г өсвөр үе, | Орон нутгийн төсөв | - | Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнийг спортын 5 | 2024 онд - спортын 7 төрлөөр, тэмцээн зохион байгуулсан байна. | - | - | Аймгийн хэмжээнд 2023 онд үндэсний спортын /шагай, мөсний шагай,сур харваа, мөсөн сур, үндэсний бөх, хурдан морь унаач/ 6 төрлөөр 42 удаагийн аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит, улсын аварга шалгаруулах тэмцээнд нийт 3210 тамирчдыг хамруулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | аварга болон нэрэмжит тэмцээн тогтмол зохион байгуулах | | залуучууд, насанд хүрэгчийн ангиллаар зохион байгуулсан байна. | | | төрлөөр зохион байгуулж байна. | | | | Тайлант онд үндэсний спортын /үндэсний бөх, үндэсний сур, мөсний сур, шагайн харваа, мөсний шагайн харваа, нумт харваа, хурдан морь/ 7 төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ангиллаар аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 48 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, 4359 тамирчдыг оролцуулсан.Үүнд:<br>-Шагайн харваа, мөсний шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 14 удаагийн тэмцээнд 1810 харваачид;<br>-Үндэсний сур харваа, мөсний сур харвааны аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнд 4 удаагийн тэмцээнд 324 харваачид:<br>-Үндэсний бөхийн барилдааныг өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн ангиллаар 30 удаагийн барилдаанд 2225 тамирчид тус тус оролцсон.<br>Зохион байгуулсан тэмцээн уралдааныг тухай бүр аймгийн хэвлэл мэдээлэл болон телевизээр иргэдэд сурталчилсан. | |
| 14 | | Үндэсний спортыг аймгийн өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах, | - | Аймгийн Үндэсний спортын холбоод, багш, дасгалжуулагч нартай хамтран өсвөр үе, хүүхэд багачуудад үндэсний спортыг сурталчлан таниулж, өвлөн | - | - | - | Үндэсний спортыг өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор Цоллооч хүүхэд шалгаруулах уралдаан | - | - | Үндэсний спортыг өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах зорилгоор 2023 онд “Цоллооч, магтаал ерөөлч хүүхэд” шалгаруулах уралдааныг сургуулийн өмнөх боловсролын 18 байгууллагын дунд 2 үе шаттай зохион байгуулж, 2 дахь шатны шалгаруулалтад 60 хүүхэд оролцсон.<br><br>Тайлант онд “Үндэсний бөх цоллооч” хүүхдийн уралдааныг сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагын дунд 2 үе шаттай зохион байгуулсан.Уралдааны 1-р шатанд 420 хүүхэд, 2-р шатны шалгаруулалтад 84 хүүхэд оролцож, эхний 3 байр эзлүүлэн дүгнэж, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | уламжлуулах зорилгоор бөхийн цол дуудах Цоллооч хүүхэд шалгаруулах уралдааныг зохион байгуулсан байна. | | | | ыг зохион явуулсан байна. 2024 онд – 55 хүүхэд оролцсон байна. | | | |
| 15 | Зорилт 4. Спортын сургалт дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын улс, бүс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, | Аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах улс, бүс, олон улсын түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах | 2021-2024 | Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 17 төрлөөр 196 тамирчин бэлтгэсэн байна. | Орон нутгийн төсөв | - | 2020 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь спортын 14 төрөлд 140 тамирчин. | 2024 онд спортын 17 төрөлд 196 тамирчин | Орон нутгийн төсөв -40.0 сая төгрөг | Орон нутгийн төсөв -40.0 сая төгрөг | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багт 2021-2023 онд спортын 16 төрөлд 182 тамирчин хичээллэсэн.<br><br>Тайлант онд өсвөрийн шигшээ 17 багийн 3 багт тамирчдыг 14-өөр нэмэгдүүлж, 196 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна.Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 17 төрлөөр зохион байгуулж, нийт 4093 өсвөрийн тамирчид хамруулж, орон нутгийн төсвөөс 40.0 сая төгрөг зарцуулсан.Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 17 тэмцээнд 1510 тамирчныг оролцуулж, 181 медаль, бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 102 медаль тус тус авсан амжилтыг үзүүлсэн.<br>Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо: сагсан бөмбөг 3х3 төрөлд 8, сагсан бөмбөгийн 5х5 төрөлд 22 хүүхэд, байт харваа-6, гимнастик-8, цана-16, хөл бөмбөг-20, бадминтон-6, бокс-10, буудлага-8, таеквондо-10, ширээний теннис-6, самбо, жүдо-18, чөлөөт бөх-12, волейбол-22, даам, шатар-8, хөнгөн атлетик-16 тамирчин тус тус хичээллэж байна. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | | Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жил бүр мөнгөн шагнал олгох | 2021-2024 | Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тамирчдын тоо | Орон нутгийн төсөв | - | 2020 онд цар тахлын үеийн хөл хорионы улмаас тэмцээн ихэнх уралдаан тэмцээн зохиогдоогүй тул тамирчдад мөнгөн шагнал өгөөгүй. | 2024 онд 370 тамирчинд 35.0 сая төгрөг | Орон нутгийн төсөв -51.7 сая төгрөг | Орон нутгийн төсөв -51.7 сая төгрөг | Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу<br>-2022 онд амжилт гаргасан нийт 455 тамирчинд 39.5 сая төгрөг, амжилт гаргасан шилдэг 5 дасгалжуулагч, 5 спорт холбоодод 4.7 сая төгрөг, нийт 44.2 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон.<br>-2023 онд дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд медаль авч, өндөр амжилт гаргасан 444 тамирчин, 5 шилдэг спорт холбоо, 5 шилдэг дасгалжуулагч нарт нийт 51.730.0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон. | 100% |
| 17 | | Үндэсний хэмжээнд зохиогдох спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд орон нутгийн тамирчдыг амжилттай оролцуулж, амжилт гаргах | 2021-2024 | Хүүхдийн спортын наадам, Монголын Бүх ард түмний наадам, Үндэсний спортын их наадам, Оюутны спортын наадамд баг тамирчдыг амжилттай бэлтгэж оролцуулсан байна. | Орон нутгийн төсөв | - | - | 2024 онд МБАТИН – 120 тамирчин | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын дагуу 2023 онд зохиогдсон Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг амжилттай оролцож багийн дүнгээр 2-р байр эзэлж мөнгөн медаль, өргөмжлөл, цомоор, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадамд Орхон аймаг амжилттай оролцож багийн дүнгээр 4-р байр эзэлж, шилдэг спортын сургалттай сургуулиар спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Ирээдүйн-Одод” сургууль шалгарч цом өргөмжлөлөөр тус тус шагнагдсан.<br>Монголын хүүхдийн спортын зуны VII наадам 2023 оны 06 сарын 16-ны өдрөөс 06 сарын 29-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Баянхонгор аймгуудад зохион байгуулагдаж, Орхон аймгаас спортын 20 төрөлд 217 өсвөрийн тамирчин оролцож, 21 аймгийн дүнгээр 2-р байр эзэлж мөнгөн медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Тайлант онд улсын хэмжээний спортын наадам зохион байгуулагдаагүй. | |
| 18 | | Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Орон нутагт хөгжүүлж байгаа гранд гольф, софт волейболын спортыг сурталчлан жилд 4 удаа тэмцээн зохиох, хичээллэгчдийг 140-д хүргэх. | Орон нутгийн төсөв | - | Софт волейбол, гранд гольфийн спортоор 80 гаруй тамирчин хичээллэж аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 удаа зохион байгуулж байна. | 2024 он - хичээллэгчдийн тоо 140, 4 удаа тэмцээн зохион байгуулах. | - | - | Тайлант онд софт волейбол, граунд гольф, туялзуур сэлэм, бочи, корн-Холл, мас-рестлинг, гар дээр суниалтын спортын 7 төрлөөр 530 тамирчин биеийн тамир, спортын газрын А, Б заал, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н спорт цогцолборын заалнуудад 7 хоногт 6 өдөр 2 цагаар тогтмол хичээллэж, тэмцээн уралдаанд тогтмол оролцсон.Үүнд:<br>•софт волейболын спортоор 120 тамирчин;<br>•граунд гольфийн төрлөөр 130 тамирчин;<br>•туялзуур сэлэм 70 тамирчин;<br>•бочи спортын төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй 15 тамирчин;<br>•корн-holl спортын төрлөөр 45 тамирчин;<br>•мас-рестинг буюу модон барилдааны төрлөөр 40 тамирчин;<br>•гар дээр суниалтын спортын төрлөөр 30 тамирчин.<br>Тайлант онд шинээр хөгжүүлж буй бочи, корн-holl, мас-рестлинг, гар дээр суниалтын 4 тэмцээнийг зохион байгуулж, 579 тамирчдыг оролцуулсан. Үүнд:<br>-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Төлөөлөгч нарын дундах спортын 4 төрөлт тэмцээн”-д Корн холлын аварга шалгаруулах тэмцээнд 12 төлөөлөгч оролцсон.<br>-Баян-Өндөр сумын 30 жилийн ойн нэрэмжит “Гар дээр суниалтын аварга шалгаруулах тэмцээн”-д 351 тамирчин, Жаргалант суманд зохион байгуулсан тэмцээнд 50 тамирчин тус тус оролцсон.<br>-Бочигийн олон хотын аварга шалгаруулах тэмцээнд 5 багийн 124 тамирчин;<br>-Иргэдийн спортын наадмын 8 төрөлт тэмцээний Мас-рестлингийн аварга шалгаруулах тэмцээнд 21 багийн 42 тамирчин тус тус оролцсон.<br>Бочигийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс Орхон аймгийн тамирчид 8 алт, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 2 мөнгө, 3 хүрэл медаль авсан амжилтыг үзүүлсэн. | |
| 19 | | Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг нэмэгдүүлэх | 2021-2024 | Өвлийн спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд хичээллэгчдийн тоог нэмэгдүүлж, тамирчдыг чадварыг сайжруулах, аймгийн аварга болон нэрэмжит тэмцээний г зохион байгуулах | Орон нутгийн төсөв | - | Өвлийн спортоор хичээллэгчид -1400 хүн Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 3 төрлөөр зохион байгуулсан. | Аймгийн аварга шалгаруулах тэмцээний г спортын 4 төрлөөр жил бүр зохион байгуулсан байна. 2024 онд -2240 хүн хүргэх. | Орон нутгийн төсөв -10.0 сая төгрөг | Орон нутгийн төсөв -10.0 сая төгрөг | Аймгийн хэмжээнд өвлийн спортын 8 /хоккей, биатлон, гүйлтийн цана, уулын цана, тэшүүр, сноүборд, мөсний шагай, мөсний сур харваа/ төрлөөр 2660 иргэд хичээллэж байна.Үүнээс 560 нь мэргэжлийн тамирчид байна.<br><br>2023 онд Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг Орхон аймагтаа амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.Үүнд:<br>-Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, уулын цана, гүйлтийн цана, шайбтай хоккей, үзүүлэх төрлөөр сноүбоардын тэмцээнд 8 аймаг, 7 дүүргийн 259 тамирчдын, 17 дасгалжуулагч ;<br>-Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадамд үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, уулын цана, гүйлтийн цана, шайбтай хоккей, үзүүлэх төрлөөр сноүбоардын тэмцээнд 13 аймаг, 7 дүүргийн 490 тамирчин, 24 дасгалжуулагч тус тус амжилттай оролцсон.<br><br>Өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Эрдэнэт мөнгөн өвөл-2023” аяныг зохион байгуулж, уулын цанын сноүбоард, гүйлтийн тэшүүр, гүйлтийн цанын тэмцээний 2 насны ангилалд 8 аймаг, 5 клубийн 221 тамирчин оролцсон.<br><br>Тайлант онд аймагтаа өвлийн спортын төрлүүдээр улсын аварга шалгаруулах тэмцээн 4 удаа, олон хотын болон аймгийн | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | аварга шалгаруулах, нэрэмжит тэмцээнийг 5 удаа зохион байгуулсан. Үүнд:<br>-Хоккейн ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд 6 багийн 120 тамирчин;<br>-Авто спортын улсын аварга шалгаруулах тэмцээнийг "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-ийн мөсөн талбайд зохион байгуулж, 54 тамирчин;<br>-Гүйлтийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээнийг "Сархиа бааз"-д зохион байгуулж өсвөрийн үеийн тэмцээнд 12 багийн 150 тамирчид, насанд хүрэгчдийн тэмцээнд 7 багийн 40 тамирчин;<br>-Биатлоны улсын аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ амралтын баазад зохион байгуулж, 7 багийн 60 тамирчин;<br>-"Эрдэнэт мөнгөн өвөл-2024" аяны хүрээнд гүйлтийн цанын бүсийн тэмцээнийг 2 насны ангиллаар зохион байгуулж, 12 багийн 190 тамирчин;<br>-Мөсний шагай аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 8 багийн 64 тамирчин;<br>-Баян-Өндөр сумын 30 жилийн ойн хүрээнд сумын аварга шалгаруулах мөсний шагайн тэмцээнд 24 багийн 192 тамирчин;<br>-Мөсний сур харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 11 багийн 88 тамирчин тус тус оролцсон. | |
| 20 | | "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн болон ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд өвлийн | 2021-2024 | Өвлийн улиралд ерөнхий боловсролын 3 сургуулийн гадна талбайд мөсөн гулсуурын талбайг | Улс, орон нутгийн төсөв | - | Аймгийн хэмжээнд цанын бааз 1, мөсөн гулгуурын гадна талбай 3 байна. | Спорт амралтын хүрээлэнгийн урд уулын энгэрт цанын зам, ерөнхий боловсролын 3 сургуулий | Орон нутгийн төсөв -10.0 сая төгрөг | Орон нутгийн төсөв -10.0 сая төгрөг | Аймгийн хэмжээнд 2023-2024 онд 5 байршилд цанын зам 3, мөсөн талбай 5 тус тус байгуулснаас "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д гүйлтийн тэшүүрийн 400м2 тойрогт мөсөн зам талбайг байгуулахад орон нутгийн төсвийн 10,0 сая төгрөг зарцуулсан.Үүнд:<br>-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, гүйлтийн цана, снөүбоардын зам, тэшүүр хоккейн мөсөн талбай; | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | спортоор хичээллэх орчин бүрдүүлэх | | тохижуулах. | | | | н спортын гадна талбайд жил бүр мөсөн гулсуурын талбайг тохижуулж хийсэн байна. | | | - 19-р сургууль /орос сургууль/ дахь мөсөн талбай;<br>-"Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д тэшүүрийн талбай;<br>“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнд”-д мөсний шагайн талбай;<br>-15-р сургуулийн тэшүүрийн мөсөн талбайг тус тус байгуулсан. | |
| 21 | Зорилт 5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтыг хууль, журамд заасан хугацаанд гаргаж харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх | 2021-2024 | Тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр | Орон нутгийн төсөв | - | - | - | - | - | Тус газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратегийн 8 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 99.4 хувиар, 2024 онд стратегийн 8 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлж эхний хагас жилд 90.1 хувиар тус тус биелүүлэн ажилласан. | 100% |
| 22 | | Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, тайлагнах, | 2021-2024 | Тухай жилийн байгууллагын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээгээр | Улс, орон нутгийн төсөв | - | - | - | - | - | Тус газар нь 2023-2024 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол 1, Ерөнхийлөгчийн зарлиг 4, Засгийн газрын тогтоол 2, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол 14 тус тус хэрэгжүүлэн ажиллаж аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороонд хагас, бүтэн жилээр тус тус тайлагнаж ажилласан. | 100% |
| 23 | | Ажилтан, албан хаагчдын ажиллах | 2021-2024 | Албан хаагчдын ажиллах нөхцөл, | Улс, орон нутгийн төсөв | - | - | Албан хаагчдын ажиллах нөхцөл, | - | - | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр/2022-2025 он/-ийг 2023-2024 онд хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 80%-тай байна. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах | | нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо | | | | нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо | | | Хөтөлбөрийн хүрээнд 2023 онд Биеийн тамир, спортын улсын хорооноос улсын төсвийн санхүүжилтээр ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажилласан. Үүнд:20 сая төгрөгийн компьютер, хувилах, хэвлэх төхөөрөмж, 20 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, 20 сая төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 60 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдаж, компьютер, хэвлэх, хувилах машинаар 90 хувь хангагдсан. Түүнчлэн аймгаас хэрэгжүүлж буй "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийн хүрээн"-нд албан хаагчдын орон сууцны нөхцөлөө сайжруулж засварлахад 2023 онд 2 албан хаагчийг санхүүгийн дэмжлэгт хамруулж, 2024 онд 2 албан хаагчийг хамруулахаар хүсэлтийг хүргүүлсэн. | |
| 24 | | Байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах | 2021-2024 | Биеийн тамир, спортын газрын хүний нөөцийн хөтөлбөр батлагдсан байна. | Улс, орон нутгийн төсөв | - | - | Биеийн тамир, спортын газрын хүний нөөцийн богино хугацааны хөтөлбөр батлагдаж хэрэгжүүлж ажилласан байна. | - | - | Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр /2022-2025/-г 2023-2024 онд хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 80%-тай байна. Хөтөлбөрийн хүрээнд "Монгол үндэсний бичиг"-ийн сургалтад 12 албан хаагч, ажлын байранд мэргэшүүлэх сургалтад 8 чиглэлээр 42 удаа давхардсан тоогоор 305 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг "7-4-10" 32 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 60 албан хаагч тус тус хамрагдаж, хөтөлбөрийн биелэлт 80%-тай байна.<br>Гадаад улсад зохион байгуулагдсан 2 удаагийн сургалт арга хэмжээнд 2 албан хаагчийг хамруулсан. Үүнд:<br>-Биеийн тамир, спортын улсын хорооноос "Биеийн тамирын арга зүйч нарын мэргэжил дээшлүүлэх" сургалтыг БНХАУ-ын Бээжин хотод 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 24-ний өдрүүдэд зохион байгуулж, тус сургалтад Биеийн тамир, спортын газраас 1 мэргэжилтэн хамрагдсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 сарын 01-ний өдрийн 13/05 тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийн хүрээн”-нд аймгийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 11 сарын 25-ны өдрөөс 12 сарын 03-ны өдрүүдэд БНСУ-д туршлага солилцох хөтөлбөрт Биеийн тамир, спортын газраас 1 албан хаагч хамрагдсан. | |
| 25 | Зорилт 6. Төсвийн шууд захирагч хууль тогтоомжийн дагуу төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах | 2021-2024 | Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв | Улс, орон нутгийн төсөв | - | Жил бүр батлагдсан төсвийг хуулийн дагуу захиран зарцуулж байна. | Жил бүрийн батлагдсан төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд | 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн байдлаар улсын төсвөөс 893,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 488,4 сая төгрөг | Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 2023 оны 12 дугаар сарын 02-ний байдлаар улсын төсвөөс 893.0 сая төгрөг, А болон Б спорт заалны урсгал зардалд орон нутгийн төсвөөс 488.4 сая төгрөгийг төсвийн тухай хуулийн дагуу тус тус зарцуулан ажилласан.<br><br>Тайлант оны 12 дугаар сарын 02-ний өдрийн байдлаар улсын төсвөөс 482.7 сая төгрөг, А болон Б спорт заалны урсгал зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, орон нутгийн нэмэгдэл цалин хөлс, тэмцээн уралдаанд орон нутгийн төсвөөс 657.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсвийн тухай хуулийн дагуу зарцуулсан. А, Б заал, “Эрдэнэт спорт, амралтын хүрээлэн”-ээс 52.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэн ажилласан. | 100% |
| 26 | Зорилт 7. Хөрш зэргэлдээ Булган аймагтай | Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын | 2021-2024 | Орхон, Булган аймгийн Биеийн тамир, | Орон нутгийн төсөв | - | 2016-2020 онд Орхон, Булган аймгийн Засаг дарга | Орхон, Булган аймгийн Биеийн тамир, | - | - | 2023-2024 онд Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний дагуу тэмцээн уралдаан хамтран зохион байгуулах, техник хэрэгслээр туслалцаа үзүүлэх, тамирчдын хамтарсан | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх | хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хханган ажиллах | | спортын газрын дарга нар хамтран ажиллах ажлын гэрээ байгуулан жил бүр ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна. | | | нарын хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлт 100% дүгнэгдсэн. | спортын газрын дарга нар хамтран ажиллах ажлын гэрээ байгуулан жил бүр ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна. | | | бэлтгэл хийх 4 зорилт арга хэмжээг 100 хувиар хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:<br><br>-Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр мэргэжилтэн, багш дасгалжуулагч, арга зүйчдийг туршлага судлуулах, хамтарсан сургалт зохион байгуулж, боловсон хүчний чадавхыг сайжруулах заалтын хүрээнд Булган аймагт зохион байгуулагдсан “Хангайн бүсийн сургаалт, тэмцээн”-д Эрдэнэт “үйлдвэр” ТӨҮГ-ын Спорт цогцолборын 11 арга зүйч, дасгалжуулагч, Биеийн тамир спорытн газраас 21 албан хаагч, Иргэдийн спортын наадам, төрийн албан хаагчдын тэмцээнд Орхон аймгаас 11 шүүгч очиж ажилласан.<br><br>-Үндэсний спорт, өвлийн спорт, өсвөрийн шигшээ баг тамирчдын хамтарсан бэлтгэл сургалт, дасгалжуулалт, нөхөрсөг уралдаан, тэмцээн зохион байгуулах заалтын хүрээнд Мөсний шагайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Булган аймагтай хамтран зохион байгуулж, Булган, Дархан, Сэлэнгэ аймгуудын 50 гаруй тамирчид, Орхон, Булган аймгийн банкуудын “Банкир-2023” спортын 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, 100 гаруй тамирчид, “Үндэсний бөх Монголын үнэт өв” өсвөрийн бөхийн барилдааныг 21 удаа зохион байгуулж, 290 бөхчүүд оролцсоноос давхардсан тоогоор Булган аймгаас 164 бөх ирж оролцсон.Дугуйт цанын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаас 18 тамирчин, 1 дасгалжуулагч Булган аймгийн Орхон суманд 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийсэн.<br><br>-Улс, бүсийн чанартай тэмцээн, уралдаан зохион байгуулахад харилцан туслалцаа үзүүлэх заалтын хүрээнд Булган аймагт | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | зохион байгуулагдсан “Самбо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн”-д техник хэрэгслийн, Орхон аймагт амьдарч буй Булган аймгийн иргэдийн дунд "Эрч хүч-Эв нэгдэл" спортын наадмыг сагсан бөмбөг, волейболын тэмцээнд спорт заалны, Булган аймгийн Хангал суманд “Биатлоны улсын аварга шалгаруулах тэмцээн”-ийг хамтран зохион байгуулж техник хэрэгсэл, хөрөнгө санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн. Мөн спорт тоглоомын аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулахад 6 удаагийн арга хэмжээнд 18 шүүгчийн харилцан солилцож шүүн явуулсан.<br><br>-”Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Спорт цогцолбортой хамтран ажиллах, дасгалжуулагч болон тамирчид харилцан туршлага судлах заалтын хүрээнд -”Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Сархиа баазад 2023-2024 онд “Эрдэнэт мөнгөн өвөл” аяны уулын цана, гүйлтийн цана, гүйлтийн тэшүүрийн тэмцээнд Булган аймгийн тамирчдыг оролцуулан тус тус оролцуулан нээлттэй зохион байгуулсан. | |
| 27 | Зорилт 8. Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, байгууллагын дотоод хяналт шалгалтын комиссын үйл ажиллагааг | Байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн эцсийн тайланг гаргаж, хугацаанд нь хүргүүлэх, хамтран ажиллах гэрээ | - | Жил бүр байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлж, хамтран ажиллах гэрээ | - | - | 2020 оны хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг маягтын дагуу гаргаж ЗГТА-БТСУХ-нд хүргүүлсэн. | Жил бүр байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. Хамтран ажиллах | - | - | Тус газар нь аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан 28 спорт холбоо, клубуудтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 2023 онд улсын төсвөөс 346.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 390 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлж 242 арга хэмжээг хамтран зохион байгуулсан.<br>Тайлант онд 30 спорт холбоо, клубүүдэд улсын төсвөөс 69.1 сая төгрөг, орон нутгийн төсвийн 360.4 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлж, 264 арга хэмжээг хамтран зохион байгуулсан.<br>Байгууллагын орон тооны бус дотоод хяналт шалгалтын комисс тэмцээн уралдаанд олгосон санхүүжилтийн тайланд хяналт шалгалт явуулж 2023 онд | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан спорт холбоодын төсөвт хяналт шинжилгээ хийх | | байгуулсан спортын холбоодын батлагдсан төсөвт хяналт хийж ажилласан байна. | | | | гэрээ байгуулсан спортын холбоодын батлагдсан төсөвт хяналт хийж ажилласан байна. | | | 3, 2024 онд 2 удаа дүгнэлт зөвлөмж өгч ажилласан.<br>Биеийн тамир, спортын арга хэмжээний хэрэгжилтийн талаар 16 асуумж бүхий судалгааг 2023 онд 545 иргэнээс, 2024 онд 200 иргэнээс цахимаар авч дүгнэсэн. | |
| 28 | | Байгууллагын Дотоод хяналт шалгалтын комиссын гишүүд жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийх, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх | - | Дотоод хяналт шалгалтын комиссын гишүүд төлөвлөгөөний дагуу ажиллаж байгууллагад үүсэж болзошгүй зөрчил, дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилласан байна. | - | - | Байгууллагын даргын баталсан тушаалын дагуу “Дотоод хяналт шалгалт”-ын комисс нь 3 гишүүнтэй ажиллаж жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллаж байна. | Дотоод хяналт шалгалтын комиссын гишүүд төлөвлөгөөний дагуу ажиллаж байгууллагад үүсэж болзошгүй зөрчил, дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилласан байна. | - | - | Байгууллагын дотоод хяналт шалгалтын орон тооны бус комиссын 2023 онд 4 чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br><br>Байгууллагын орон тооны бус дотоод хяналт шалгалт комисс нь 2024 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж зохион байгуулагдсан тэмцээн уралдааны санхүүгийн тайлан болон биеийн тамир, спортын төрийн бус байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт зэрэгт төлөвлөгөөт хяналтыг 3 удаа, төлөвлөгөөт бус хяналтыг 1 удаа зохион байгуулж, дүгнэлт зөвлөмж өгч ажилласан. | 100% |

---oOo----